



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization

Mongolia



НҮБ-ын Хүүхдийн Сан



ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТ

БАГШ НАРТ ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр хэвлэв.

Монгол Улсын Дархлаажуулалтын тухай хууль, “Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлал”-ын дагуу ХПВ-ийн эсрэг вакцинаар 11 настай бүх хүүхдийг дархлаажуулна. Уг дархлаажуулалтыг Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан А/53, А/37 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл аюулгүй сургууль, арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөө 2025-2028”, А/484, А/291 дүгээр тушаалаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагад суурилсан дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай” тушаалын дагуу сургуульд суурилан зохион байгуулах түл багш нарт зориулан ХПВ-ийн хэв шинжээр үүсгэгддэг өвчнүүд, урьдчилан сэргийлэлт, вакцины талаар нотолгоонд суурилсан мэдээллийг хүргэж байна. 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн байлдлаар 33,955 гаруй хүүхдийг дархлаажуулаад байна. Эдгээр хүүхдүүдэд ямар нэгэн урвал, хүндрэл гараагүй болно.

1. ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУС (ХПВ):

- Одоогоор ХПВ-ийн 200 гаруй хэв шинж байна.
- Ам, залгиур, хоолой, толгой, хүзүү, үтрээ, бэлгийн уруул, хошногоны амсар, шодой, шулуун гэдэсний хортой болон хоргүй хавдар, үү ургацгийг эрэгтэй, эмэгтэй хүмүүст үүсгэдэг.
- Хавдар үүсгэх өндөр эрсдэлтэй ХПВ-ийн 14 хэв шинжийг (16, 18, 31, 33, 35, 39, 45, 51, 52, 56, 58, 59, 66, 68) тодорхойлсон бөгөөд УХХХ-ын нийт тохиолдлын 70 гаруй хувь нь ХПВ 16, 18 хэв шинжээр үүсгэгддэг.

2. ХПВ-ИЙН ДАМЖИХ ЗАМ:

- ХПВ-ийн халдвар гол төлөв бэлгийн замаар дамжина. (тэр дундаа аман болон аман бүс хавьтлаар)
- Төрөх үед эхээс хүүхдэд дамжих эрсдэлтэй.
- Бэлгийн анхны хавьтлаар халдвар авах эрсдэл өндөр бөгөөд халдвар авсан ихэнх тохиолдолд шинж тэмдэг илрэхгүй.

3. ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ (ХАРЬЦУУЛАЛТ):

- Манай улс хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 45 дугаарт ордог.
- Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 100,000 хүн амд 181.5 тохиолдол ногдож, 185 орноос 1 дүгээрт байна.



УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДАР



- УХХХ-ын түвшингээр дэлхийн 185 орноос 53 дугаарт орж, дэлхийн дунджаас 3 дахин, Азийн орнуудын дунджаас 1.5 дахин өндөр байна.
- УХХХ-ын шалтгаант нас баралтын түвшингээр дэлхийн дунджаас 1.3 дахин, Азийн орнуудын дунджаас 2 дахин өндөр байна.

4. УХХХ-ЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ:

- Манай улсад УХХХ нь эмэгтэйчүүдэд зонхилон тохиолдох хавдрын 2 дугаарт, нийт хорт хавдрын шинэ тохиолдлын 4 дүгээрт, нас баралтын 5 дугаарт орж байна.
- 2024 онд УХХХ-ын 521 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өдөр бүр 1-2 эмэгтэй энэ хавдраар оношлогдож байна гэсэн үг.
- Жилд дунджаар 160 эмэгтэй энэ хавдраар нас барж, төдий тооны гэр бүл өнчирч байна.

5. ХПВ-ИЙН ШАЛТГААНТ ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ АРГА:

- Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд 27 наснаас эхлэн 3 жил тутам орох, Умайн хүзүүний эсийн шинжилгээ (ПАП) хийлгэх, 30, 40 насанд ХПВ-ийн өндөр эрсдэлтэй 14 хэв шинжийг илрүүлэх ПГУ шинжилгээ хийлгэх
- ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах.

6. УХХХ-ЫН ТАЛААРХ ДЭМБ-ЫН ЗОРИЛТ/ 90/70/90/:

- 2030 он гэхэд дэлхийн 15 нас хүртэлх бүх охидын 90 хувийг ХПВ-ийн эсрэг вакцинаар дархлаажуулах,
- Эмэгтэйчүүдийн 70 хувийг эрт илрүүлэгт хамруулах,
- УХХХ-ыг 90 хувийг бүрэн эмчлэх менежмент.

7. ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН:

- Дэлхийн 150 гаруй орон товлолын дархлаажуулалтаар 9-14 насны хүүхдэд хийж байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 472 тоот тогтоолоор баталсан үндэсний товлолын дагуу 11 насны бүх хүүхдийг ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаар нэг удаа дархлаажуулна.
- Манай улс 2006 онд ДЭМБ-аас зөвшөөрөл авсан, АНУ-ын Мерк үйлдвэрийн ХПВ-ийн халдварын эсрэг 4 цэнт вакциныг хэрэглэж байна. Энэхүү вакцин нь ХПВ-ийн 6, 11, 16, 18-р хэв шинжүүдээс сэргийлэх төдийгүй 31, 33, 45-р хэв шинжээс давхар хамгаалдаг бөгөөд 1 тунгаар савлагдсан. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь ДНХ-ийн рекомбинант аргаар ХПВ-ийн хэв шинж тус бүрээс бүрхүүл уургийг цэвэршүүлэн гаргаж авсан вирус төст хэсгүүдийг агуулдаг. Уг вакцин нь вирусийн ДНХ-ийг агуулдаггүй, амьд вакцин биш тул эсийг халдварлуулж, үрждэггүй, ХПВ-ийн халдвар эсвэл хавдар үүсгэдэггүй.

8. ВАКЦИНЫ ҮР ДҮНГИЙН СУДАЛГАА:

- Дэлхийн олон улсад тус вакциныг нэвтрүүлээд 18 жил болж байгаа бөгөөд УХХХ болон бусад хортой болон хоргүй хавдрын өвчлөл, эндэгдлийг бууруулсан нотолгоо, үр дүн гарсаар байна.
- ХПВ-ийн эсрэг 4 цэнт вакцин нь ХПВ-ийн 16, 18 хэв шинжийн шалтгаант УХХХ-ыг 70-80 хувь бууруулдаг.
- АНУ, Австрали, Дани, Шотланд зэрэг вакциныг эрт нэвтрүүлсэн олон оронд ХПВ-ийн 16,18 хэв шинжээс үүдэлтэй УХХХ-ын тархалт 66-83 хувь буурч, хөвгүүдийн бэлгийн үү 48 хувиар буурсан байна.
- Швед улсад ХПВ-ийн эсрэг вакцин хийснээр УХХХ 88 хувиар буурсан байна.
- Монгол улсад 2016 онд нийслэлийн Баянгол, Багануур дүүрэг, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн ХПВ-ийн халдварын эсрэг вакцины 3 тунд хамрагдсан 925, ижил насны, вакцинд хамрагдаагүй 978 эмэгтэйчүүдийг вакцин хийснээс хойш 5 жилийн дараа дагаж судалсан “Хавдрын Үндэсний Зөвлөл НҮТББ-ын” судалгаагаар вакцинд хамрагдсан бүлэгт ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжийн тархалт вакцинд хамрагдаагүй бүлэгтэй харьцуулахад 4 дахин буурч, түүн дотроо ХПВ 16-р хэв шинжийн тархалт 10 дахин буурсан байна.
- Мөн дээрх эмэгтэйчүүдийг тус байгууллагаас 11 жилийн дараа дагаж судлахад вакцинд хамрагдсан бүлэгт ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжийн тархалт вакцинд хамрагдаагүй бүлэгтэй харьцуулахад 9 дахин буурч, түүн дотроо ХПВ 16-р хэв шинжийн тархалт 8 дахин буурсан байна. ХПВ-ийн вакцин нь ХПВ-ийн өндөр эрсдэлтэй 16-р хэв шинжээс 5 жилийн дараа 90 хувь, 11 жилийн дараа 100 хувь хамгаалсан үр дүн гарсан байна.
- Түүнчлэн дээрх судалгаагаар жирэмслэлт болон төрөлт ХПВ-ийн эсрэг вакцинд хамрагдсан бүлэг болон вакцингүй тухайн насны бүлэгт 5 ,11 жилийн дараа ижил байсан бөгөөд жирэмслэлт, төрөлтөд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй байна.

9. ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ ХАРИУ УРВАЛ:

- ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь бусад вакцины адил халуурах, бөөлжих, дотор муухайрах, толгой эргэх, толгой өвдөх болон тарилга хийлгэсэн газар хөндүүрлэх, хавдах, улайх, загатнах, хөхрөх шинжүүд илэрч болно. Энэ нь 2-3 өдрийн дараа эмчилгээ шаардлагагүйгээр өөрөө аяндаа арилна.
- Маш ховор тохиолдолд анафилаксийн урвал, дархлаажуулалттай давхацсан эмгэг илэрч болно (1 сая хүнд 1.6 тохиолдол).

10. ВАКЦИНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ДҮН:

- ХПВ-ийн эсрэг вакцины 1 тунгийн үнэ 19 мянган төгрөг,
- УХХХ-ын зөвхөн мэс заслын эмчилгээний зардал 3 сая төгрөг,
- Дотуур туяа эмчилгээний зардал 9 сая төгрөг,
- Эмийн эмчилгээнд 7 сая төгрөг, дунджаар 1 хүний эмчилгээнд 19-20 сая төгрөгийг ЭМД-аас гаргаж байна.

11. ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫГ СУРГУУЛЬ ДЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХАД БАГШ НАР ДАРААХ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭН ХАМТРАН АЖИЛЛАНА. ҮҮНД:

1. Ангийн багш нар Хүний папиллома вирусийн халдвар, түүнээс сэргийлэх тухай мэдээллийг дархлаажуулалт эхлэхээс өмнө 7 хоногийн өмнө эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэсэн байна.
2. Багш нар эцэг эх, асран хамгаалагч нар дээрх мэдээлэлтэй танилцсан эсэхийг лавлана.

3. Дараалал зохицуулагч ангийн багш дархлаажуулалтын цэгийг эмх цэгцтэй байлгаж, хүүхдүүдэд хөдөлгөөний урсгалыг зааварчилна.
4. Хүүхдүүдийг анги, ангиар нь дараалалд оруулан хүүхдийн насыг баталгаажуулан, дархлаажуулалтын талаарх мэдээллээр хангана.
5. Вакцин хийлгэсний дараа хүүхдийг 15-30 минут ажиглалтын өрөөнд байлгана. Хэрвээ дархлаажуулалтын дараа ямар нэгэн зовиур илэрвэл сүргүүлийн болон сүм, өрхийн эмчид хандахыг хүүхдэд зөвлөнө.
6. Дархлаажуулалтын цэгт 2 цаг тутамд 10-15 минут салхивчийг нээж агаар сэлгэн, өдөрт 2-оос доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ хийлгэнэ.
7. Дархлаажуулалтын цэгийн бүх өрөөнд хүүхдүүдийг суулган тайван, тав тухтай байлгана.



ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ДАРХЛААЖУУЛАЛТАД НЭВТРҮҮЛСЭН ОРНУУДАД ИРГЭД ОЛОН НИЙТЭЭС ГАРСАН ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТУУД:

- ХПВ-ийн халдвар авснаас хойш ямар хугацаанд хорт хавдар үүсэх вэ?
 - ◊ Халдвар авсан ихэнх хүмүүст шинж тэмдэг илрэхгүй. Хэрэв УХХХ үүсгэдэг ХПВ-ийн олон хэв шинжийн халдвар авч, удаан хугацаанд үргэлжилбэл эмэгтэйчүүдэд хавдрын өмнөх эмгэгүүд (умайн хүзүүний улайлт, шархлаа) үүсч, эмчилгээ хийлгээгүй тохиолдолд УХХХ болно. ХПВ-ийн халдвар авснаас хойш УХХХ үүсэх хугацаа ойролцоогоор 15-20 жил байдаг. 45 нас хүрсэн нийт хүмүүсийн 80 гаруй хувь нь ХПВ-ийн халдварыг авсан байдаг. Харин 10 хувь орчим нь ХПВ-ийн шалтгаант умайн хүзүүний хорт хавдар, умайн хүзүүний хорт хавдрын урьдал, үтрээ, хошногоны хорт хавдар, ам залгиурын хорт хавдар, шодойн хорт хавдар, бэлгийн үү ургацаг үүсэх шалтгаан болж байна.
- Умайн хүзүүний хорт хавдар гэж юу вэ?
 - ◊ Умайн хүзүүний хэвийн бус эсүүд маш хурдан өсч, цаг хугацаа өнгөрөх тусам хорт хавдрын эсүүд болж үржин цаашлаад биеийн бусад хэсэгт тархдаг. УХХХ-ыг эрт оношилбол эмчлэх боломжтой. Харин эрт илрүүлж, эмчилгээ хийгээгүй тохиолдолд үхэлд хүргэнэ. Жил бүр

дэлхий даяар 266,000 эмэгтэй УХХХ-ын улмаас нас бардаг бөгөөд тэдний 85 гаруй хувь нь хөгжиж буй орнуудын эмэгтэйчүүд байна.

- **Эмэгтэй хүн УХХХ-тай эсэхийг гаднаас нь хараад мэдэх боломжтой юу?**

- ◊ Үгүй. УХХХ-аар өвдсөн эмэгтэй ч өөрөө өвчин хүндэртэл мэддэггүй. Тиймээс УХХХ-ыг илрүүлэхийн тулд эрт илрүүлэг, эсийн шинжилгээ ПАП, өндөр эрсдэлтэй ХПВ-ийн хэв шинжийг илрүүлэх ПГУ шинжилгээ хийлгэх шаардлагатай.

- **УХХХ-ын эрсдэлт хүчин зүйл юу вэ?**

- ◊ УХХХ-ын үндсэн эрсдэлт хүчин зүйл нь ХПВ-ийн өндөр эрсдэл бүхий хэв шинжийн халдвар байдаг. Бусад эрсдэлт хүчин зүйлсэд:

- Бэлгийн харьцаанд эрт орох,
- 3 ба түүнээс дээш удаа жирэмслэх,
- Тамхи татах,
- Дархлаа сул байх, ХДХВ-ийн халдвартай байх,
- Бэлгийн замын бусад халдвартай байх зэрэг ордог.

- **Вакцинаар ХПВ-ийн халдвар болон УХХХ-ыг эмчилж болох үү?**

- ◊ Вакцины нэг түн хийлгэснээр халдвараас 98-100 хувь хамгаалдаг. Вакцин үрт хугацааны дархлаа тогтоох боломжтой гэдгийг олон улсын судалгаагаар тогтоосон. ХПВ-ийн эсрэг 4 цэнт вакцин нь ХПВ-ийн шалтгаант УХХХ-ыг зонхилон үүсгэдэг 16, 18 хэв шинжийн халдварыг 70-80 хувь буруулдаг. Дархлаажуулалт хийснээс 10 жилийн дараах үр дүнг судалсан судалгаанаас харахад 9-16 насны вакцин хийлгэсэн охидыг вакцин хийлгээгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад умайн хүзүүний хорт хавдраар өвчлөх эрсдлийг 88 хувиар бүүруулсан байна.

- ◊ Вакциныг анхны бэлгийн харьцаанд орохоос өмнө хийвэл илүү үр дүнтэй бөгөөд ам, залгиур, хоолой, толгой, хүзүү, үтрээ, бэлгийн уруул, хошногны амсар, шодой, шулуун гэдэсний зэрэг хортой болон хоргүй хавдар, үү ургацгаас сэргийлэх ач холбогдолтой.

- **ХПВ-ийн халдварын эсрэг вакцин олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үү?**

- ◊ АНУ-ын Хүнс, эмийн байгууллага, Европын Эмийн агентлаг зэрэг олон орны үндэсний зохицуулах агентлагаас зөвшөөрөлтэй бөгөөд аюулгүй, үр дүнтэй болохыг тогтоосон. Одоогийн байдлаар дэлхийн 150 гаруй орон ДЭМБ-ын албан ёсны зөвшөөрөл бүхий ХПВ-ийн эсрэг 6 төрлийн вакциныг хэрэглэж байна. Үүнд:

- 2 цэнт вакцин: өндөр эрсдэлтэй ХПВ-ийн 16, 18-р хэв шинжүүдээс хамгаална.
- 4 цэнт вакцин: ХПВ-ийн 6, 11, 16, 18-р хэв шинжүүдээс хамгаална.
- 9 цэнт вакцин: ХПВ-ийн 6, 11, 16, 18, 31, 33, 45, 52 болон 58-р хэв шинжүүдээс хамгаална.

- ◊ Манай улс дээр дурдсан байгууллагуудын зөвшөөрөл бүхий АНУ-ын Мерк үйлдвэрийн ХПВ-ийн халдварын эсрэг 4 цэнт вакциныг хэрэглэж байна. Энэхүү вакцин нь ХПВ-ийн 6, 11, 16, 18-р хэв шинжүүдээс сэргийлэх төдийгүй 31, 33, 45-р хэв шинжээс давхар хамгаалдаг бөгөөд 1 тунгаар савлагдсан.

- **ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлага дахь бодисууд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?**

- ◊ Вакцины найрлага дахь бодисууд хүний биед аюулгүй. Вакцин нь бусад эмийн адил нэмэлт бодисыг маш бага хэмжээгээр агуулсан байдаг.

Нэмэлт бодисууд нь ХПВ-ийн халдварын эсрэг вакцины үйлчилгээг үр дүнтэй болгох зориулалттай бөгөөд бусад вакцин, эмийн найрлагад адилхан бага тунгаар агуулагдаж байдаг. Тухайлбал:

- Хөнгөн цагааны давсыг 80 гаруй жил вакцины үйлдвэрлэлд ашиглаж ирсэн. Вакцин дахь хөнгөн цагааны давсны агууламж маш бага хэмжээтэй байдаг.

- Л-гистидин нь хоол хүнсэн дэх чухал амин хүчлийн нэг бөгөөд элэгний хавдрын эсрэг зарим вакцины найрлагад ордог.
- Полисорбат-80 нь мөхөөлдөс зэрэг зарим хүнсний найрлагад ордог. Зарим төрлийн хүүхдийн вакцин болон эмийн найрлагад агуулагддаг.
- Борын натрийн давс нь зарим төрлийн вакцин болон нүдний дусаалга зэрэг эмийн найрлагад ордог.
- Натрийн хлоридын давс нь хүний биеийн хэвийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй давс.
- Натрийн фосфатын давснууд нь түгээмэл хэрэглэгддэг, аюулгүй юм. Эдгээр нь хүчил шүлтийн тэнцвэртэй байдлыг хангах, вакцины идэвхтэй нэгдлүүдийг тунахаас сэргийлдэг.
- **Яагаад вакцинд хөнгөн цагаан агуулагддаг вэ? Энэ нь хүний биед хэр аюултай вэ?**
 - ◊ Вакцины аюулгүй байдлын дэлхийн зөвлөлдөх хороо бүх нотолгоо, судалгааг тогтмол хянасны үндсэн дээр хөнгөн цагаан агуулсан вакцин эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл байхгүй байна гэж дүгнэсэн. Вакцин дахь хөнгөн цагааны агууламж маш өчүүхэн байдаг. Хүн өдөр тутмын хоол хүнсээр дамжуулан вакцинтай харьцуулахад 35 дахин их хэмжээний хөнгөн цагааныг авдаг. Хөнгөн цагаан нь жимс, хүнсний ногоо, шар айраг, дарс, амтлагч, гурил, үр тариа, самар, сүүн бүтээгдэхүүн, хүүхдийн сүүн тэжээл, зөгийн бал зэрэг олон төрлийн хоол хүнс, ундаанд агуулагддаг бөгөөд насанд хүрэгчид өдөрт 7-9 миллиграмм хөнгөн цагаан хэрэглэдэг. Харин ХПВ-ийн халдварын эсрэг вакцинд хөнгөн цагааны давс 225 микрограмм агуулагддаг.
- **ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлагад мөнгөн ус ордог уу?**
 - ◊ Үгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлагад тиомеросал буюу мөнгөн ус агуулагддаггүй.
- **ХПВ-ийн халдварын эсрэг вакцинд хичнээн хүн хамрагдсан бэ?**
 - ◊ Дэлхий дахинд 2006 оноос хойш ХПВ-ийн халдварын эсрэг вакцинд 270 гаруй сая хүн хамрагдаад байна.
- **ХПВ-ийн вакциныг өмнө нь манай улсад хэрэглэж байсан уу?**
 - ◊ Тийм. Манай улсад 2012 онд 10 мянга гаруй охидод ХПВ-ийн эсрэг вакциныг 3 тунгаар хийсэн. Үүнээс хойш сайн дурын дархлаажуулалтаар хийж байна.
- **ХПВ-ийн эсрэг вакцин хийлгээд тухайн вирусийн халдвар авах уу?**
 - ◊ Уг вакцин нь вирусийн ДНХ-ийг агуулдаггүй, амьд вакцин биш тул эсийг халдварлуулж, үрждэггүй, ХПВ-ийн халдвар эсвэл хавдар үүсгэдэггүй. Харин ХПВ-ийн эсрэг 4 цэнт вакцин хийлгэснээр ХПВ-ийн 6, 11, 16, 18-р хэв шинжүүдээс сэргийлэх төдийгүй 31, 33, 45-р хэв шинжээс давхар хамгаалагдаж, тэдгээрээр үүсгэгддэг хортой, хоргүй хавдраас сэргийлнэ.
- **ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг яаж гаргаж авсан бэ?**
 - ◊ ХПВ-ийн халдварын эсрэг вакцинууд нь ХПВ-ийн бүрхүүл уургийг цэвэршүүлэх замаар гаргаж авсан рекомбинант идэвхигүйжүүлсэн вакцин юм.
- **ХПВ-ийн вакцинжуулалтыг хэнд хийх вэ?**
 - ◊ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 472 дугаар тогтоолоор батлагдсан “Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлал”-ын дагуу 11 настай хүүхдийг нэг тунгаар дархлаажуулна.
- **Яагаад ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг 11 насны хүүхдүүдэд хийх вэ?**
 - ◊ Өсвөр насны хүүхдийг бэлгийн харьцаанд орохоос нь өмнө вакцинд хамруулах нь хамгийн үр дүнтэй байдаг. 11 настай хүүхдийг дархлаажуулахад үүсэх эсрэг биеийн түвшин түүнээс дээш насныхантай харьцуулахад өндөр байдаг. Мөн хүүхдэд эрт хийснээр хүн амын дунд сүргийн дархлаа үүсгэж, вирусийн тархалтыг бууруулна.

- Хөвгүүдэд ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг хийх ёстой юу ?
 - ◊ ХПВ нь ам, залгиур, хоолой, толгой, хүзүү, хошногоны амсар, шодой, шулуун гэдэсний хортой хавдар, бэлгийн үү, ургацаг зэргийг эрэгтэй, эмэгтэй хүйсийн хүмүүст адилхан үүсгэдэг. Мөн ХПВ-ийн халдвар бэлгийн зам (аман болон аман бус хавьтал)-аар дамждаг бөгөөд эрэгтэй хүн вирус тээгч болох эрсдэлтэй. Иймээс эрэгтэй хүүхдэд вакцин хийх нь өөрийг нь болон гэр бүлийг нь ХПВ-ээр үүсгэгддэг олон төрлийн өвчлөл, хортой, хоргүй хавдраас сэргийлэх ач холбогдолтой юм.
- ХПВ-ийн эсрэг вакциныг 2 тунгаар хийж байсныг яагаад 1 тун болгосон юм бэ?
 - ◊ ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу ихэнх орнууд ХПВ-ийн эсрэг вакциныг 2 тунгаар дархлаажуултад нэвтрүүлсэн. 2023 онд ДЭМБ уг вакциныг 1 тунгаар хэрэглэх нь эрүүл мэндийн болон эдийн засгийн үр дүнтэй гэдгийг зөвлөмж болгосон. Ингэхдээ ХПВ-ийн эсрэг вакцины талаарх эрдэмтдийн судалгаа, дэлхийн дархлаажуулалтын шинжээчдийн стратегийн зөвлөх хорооны шийдвэрийг үндэслэсэн юм. Хөгжиж буй орнууд 1 тунгаар 2 хүйсээ хамгаалах нь эдийн засгийн хувьд илүү үр дүнтэй гэж үзэж байна.
- Ямар хүүхдүүдэд ХПВ-ийн эсрэг вакциныг хийж болохгүй вэ?
 - ◊ Уг вакцины найрлаганд орсон бодист харшилтай, вакцин хийлгэхээр ирэх үед халуурсан болон ямар нэг цочмог өвчнөөр өвдсөн, хорт хавдрын эсрэг хими болон туяа эмчилгээ, дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа хүүхдэд уг вакциныг хийж болохгүй. Цочмог халдварт өвчнөөр өвдсөн бол 1 сарын дараа, цочмог гепатитаар өвдсөн бол 6 сарын дараа вакцин хийлгэж болно.
- Саяхан өөр өвчний эсрэг вакцин хийлгэсэн хүүхдэд ХПВ-ийн эсрэг вакцин хийлгэж болох үү?
 - ◊ Өөр вакцин хийлгэснээс хойш 1 сарын дараа хийлгэж болно
- ХПВ-ийн халдварын эсрэг вакины дараа хариу урвал илэрдэг үү?
 - ◊ Бусад вакцины нэгэн адил ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэсний дараа тарьсан газар өвдөх (10 хүний 8 хүнд илэрдэг), улайх, хавдах, толгой өвдөх (10 хүний 3 хүнд), бага зэрэг халуурах (10 хүний 1 хүнд илэрдэг) зэрэг хөнгөн шинж тэмдэг илэрч болно. Эдгээр шинж тэмдгүүд хэдэн цагаас 1-2 өдөр үргэлжилж, аяндаа арилна.
- ХПВ-ийн халдварын эсрэг вакины дараа урт хугацааны урвал, хүндрэл илэрдэг үү?
 - ◊ Үгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь хамгийн их судлагдсан вакцин юм. Урт хугацааны туршид үзүүлсэн урвал хүндрэл бүртгэгдээгүй.
- ХПВ-ийн халдварын эсрэг вакиныг тогтмол судалдаг үү?
 - ◊ Тийм. ДЭМБ-ын Вакцины аюулгүй байдлын дэлхийн зөвлөлдөх хороо дэлхийн хэмжээнд ХПВ-ийн халдварын эсрэг вакцины аюулгүй байдлын талаар хийгдсэн бүх шинжлэх ухааны нотолгоо, судалгаанууд, вакцитай холбоотой байх магадлалтай вакцины дараах урвал хүндрэлийн тохиолдол бүрийг хянаж, тогтмол үнэлгээ хийдэг. Энэхүү хороо нь ХПВ-ийн халдварын эсрэг вакцины аюулгүй байдлыг анх 2007 онд, түүнээс хойш 2008, 2009, 2013, 2014, 2015, 2017, 2019 онд хянан үзэж, вакцитай холбоотой ноцтой урвал хүндрэл бүртгэгдээгүй тул өсвөр насны хүүхдүүдэд хийхэд аюулгүйг баталсан.
- Япон улс ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг хийж байгаа юу?
 - ◊ Тийм. Япон улс 2010 онд охидод ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг зарим мужуудад хийж эхлэн, 2013 оны 4-р сард дархлаажуулалтын үндэсний товллод оруулж, вакцины хамралт 70 хувьтай байсан. 2013 оны зун хэвлэл мэдээллээр гарсан вакцины дараах урвал хүндрэлийн талаарх мэдээлэлтэй холбоотой Японы засгийн газар ХПВ-ийн халдварын эсрэг

дархлаажуулалтын хөтөлбөрийг түр зогсоосон. Нарийн тандалт, судалгаа, үнэлгээ хийсний дараагаар 2021 оны 11-р сард Японы Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас уг вакциныг аюулгүй гэж үзэн, 12-16 насны охидод ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг хэрэглэхийг албан ёсоор зөвлөсөн.

- **ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нөхөн үржихүйд нөлөөлдөг үү?**
 - ◇ Үгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нөхөн үржихүйд нөлөө үзүүлдэггүй. 2006 онд анх лиценз авахаас өмнө хийгдсэн вакцины эмнэл зүйн туршилтууд, вакцин нэвтрүүлснээс хойших аюулгүй байдлын хяналт, судалгаанууд энэхүү вакцин эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйд ямар нэгэн асуудал үүсгэдэггүйг баталгаажуулсан байна. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь умайн хүзүүнд хавдрын урьдал эмгэг (шарх) болон умайн хүзүүний хавдар үүсэхээс хамгаалах замаар нөхөн үржихүйг хамгаалдаг.
- **ХПВ-ийн халдварын эсрэг вакцин аутизм үүсгэдэг үү?**
 - ◇ Үгүй. Олон улс (АНУ, Дани, Швед, Япон, Австрали гэх мэт)-ын эрдэмтдийн олон сая хүнийг хамруулан хийсэн судалгаагаар ХПВ-ийн эсрэг вакцин хийлгэсэн болон хийлгээгүй хүүхдүүдийн дунд аутизмын тохиолдлын ялгаа байхгүй байсан. Мөн ДЭМБ, АНУ-ын Өвчний хяналтын төв, Европын Эмийн Агентлаг, Австралийн Эрүүл мэндийн байгууллага бүгд ХПВ-ийн эсрэг вакцин аутизм үүсгэдэггүй гэдгийг албан ёсоор мэдэгдсэн байна.
- **2012 онд манай улсад хийсэн ХПВ-ийн халдварын эсрэг вакцин үр дүнтэй байсан үү?**
 - ◇ Тийм. 2012 онд ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэсэн эмэгтэйчүүдийг 11 жилийн дараа дагаж судалсан “Хавдрын Үндэсний Зөвлөл НҮТББ-ын” судалгаагаар вакцинд хамрагдсан бүлэгт ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжийн тархалт вакцинд хамрагдаагүй бүлэгтэй харьцуулахад 9 дахин буурч, түүн дотроо ХПВ 16-р хэв шинжийн тархалт 8 дахин буурсан байна. Мөн ХПВ-ийн вакцин нь ХПВ-ийн өндөр эрсдэлтэй 16-р хэв шинжээс 5 жилийн дараа 90 хувь, 11 жилийн дараа 100 хувь хамгаалсан үр дүн гарсан байна.
- **2012 онд манай улсад хийсэн ХПВ-ийн халдварын эсрэг вакцин эмэгтэйчүүдийг үргүйдэлд хүргэсэн үү?**
 - ◇ Үгүй. Нийслэлийн Баянгол, Багануур дүүрэг, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн ХПВ-ийн халдварын эсрэг 3 тун вакцинд хамрагдсан 925, ижил насны вакцинд хамрагдаагүй 978 эмэгтэйчүүдийг вакцин хийснээс хойш судалсан “Хавдрын Үндэсний Зөвлөл НҮТББ-ын” судалгаагаар жирэмслэлт болон төрөлт 5 болон 11 жилийн дараа ХПВ-ийн вакцинд хамрагдсан бүлэг болон вакцингүй тухайн насны хяналтын бүлэгт ижил байсан бөгөөд жирэмслэлт, төрөлтөд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй байна
- **ХПВ-ийн эсрэг вакцин хийлгэсний дараа анхаарах зүйлс юу вэ?**
 - ◇ ХПВ-ийн эсрэг вакцин хийлгэсний дараа ажиглалтын өрөөнд 15-30 минут байна. Тарилга хийсэн хэсэгт вакцин тариулсан өдөртөө ус хүргэхгүй, цохиж, маажиж, нухахгүй, эм, тос, ариутгалын бодис зэргийг түрхэхгүй, хүйтэн зүйл уухгүй, дулаан хувцаслах хэрэгтэй. Өөр бусад ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл эмчид яаралтай хандана.
- **ХПВ-ийн эсрэг вакцин хийлгэсний дараа ухаан алдаж унадаг үү?**
 - ◇ Өсвөр насны зарим хүүхэд тариа хийлгэх айдсаас улбаалан мүүжрах, ухаан алдах тохиолдлууд бүртгэгдсэн байдаг. Иймд вакцин хийлгэсний дараа 15-30 минут суулгаж ажиглах нь чухал.
- **Уг вакциныг хийлгээд ирээдүйд үргүй болох, гажигтай хүүхэд төрүүлэх зэрэг эрсдэл бий юу?**
 - ◇ Үгүй. Олон улсад хийсэн судалгаагаар вакцины дараа үргүйдэл үүсэх, төрөлхийн гаж хөгжилтэй хүүхэд төрсөн тохиолдол байхгүй. Мөн манай оронд ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэсэн 1000 гаруй охидыг даган судлахад үргүй болсон тохиолдол байхгүй байсан.

- Вакцины талаарх эдгээр мэдээлэлд би яагаад итгэх ёстой вэ?
 - ◇ Энэхүү мэдээлэл нь вакцины талаарх шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан дэлхий дахинд ижил байдаг зөвлөгөө мэдээлэл юм. Манай улс өртөг өндөртэй энэхүү вакциныг худалдан авч, хүүхдүүддээ хийж байгаа нь үр хүүхэд, хойч үеэ олон төрлийн хортой болон хоргүй хавдраас сэргийлж байгаа үр дүнтэй арга хэмжээ юм.
- Хэрвээ би хүүхдээ вакцинжуулах талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл хаана хандах вэ?
 - ◇ Та өрхийн эмнэлэг, эмчид хандаж өөрт хэрэгтэй мэдээллийг лавлах боломжтой. Мөн дараах байгууллагуудын албан ёсны эх сурвалжаас вакцины талаар мэдээлэл авах боломжтой. Үүнд:
 - World Health Organization [http: www.who.int](http://www.who.int)
 - U.S. Centres for Disease Control and Prevention: <https://www.cdc.gov/vaccine-safety/index.html>
 - Immunization Action Coalition: www.immunize.org
 - ХӨСҮТ: <https://www.nccd.gov.mn/>
 - ЭМЯ : <http://www.mohs.mn/> г.м
 - Фэйсбүүк хаягууд: Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Вакцин ба дархлаажуулалт

!! Вакцины талаарх буруу ташаа мэдээлэл цахим орчинд түгээмэл байдаг тул дээр дурдсантай адил баталгаатай эх сурвалжаас мэдээлэл аваарай.

Хүүхдийн ирээдүйн сайн сайхны төлөө чин сэтгэлээр хамтран ажиллаж байгаа сурган хүмүүжүүлэгч та бүхэндээ баярлалаа.

ХПВ-ийн ХАЛДВАРЫН ЭСРЭГ

ВАКЦИН

Дэлхийн
150 гаруй
орон товллын
дархлаажуулалтаар
9-14 насны хүүхдэд
хийж байна.

Дархлаажуулалтад
хэрэглэж буй вакцин нь
АНУ-д үйлдвэрлэсэн,
ДЭМБ-ын гэрчилгээтэй
1 тунгаар
савласан вакцин юм.



ХПВ-ийн 6; 11; 16; 18
дугаар хэв шинжийн
эсрэг **4 цэнт**
вакцин хэрэглэж
байна.

Товлолын дагуу
11 насны
бүх хүүхдийг нэг удаа
дархлаажуулна.

 119
 

119



Хэрэв Танд Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалттай холбоотой нэмэлт мэдээлэл, тодруулга хэрэгтэй бол 119 тусгай дугаарт залгаж лавлана уу.

ДУУДЛАГА ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ.